



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/253

Булган сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Булган аймгийн зарим багийн Засаг дарга нарыг зөөврийн компьютерээр хангах (15 ш) нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

Б.Бямбасүрэн (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэтуяа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА:  Б.АРИУН-ЭРДЭНЭ



116323010236